

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/257/НА-СТА-ТШЗ

Цахим
www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

хуудас:

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас:261663 Цахим хаяг: naranchimeg@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Энхбаатар
Утас:261885 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn
Аудитор: С.Алтанхуяг
Утас:263533 Цахим хаяг: altankhuyags@audit.gov.mn
Гроут финанс аудит ХХК-ийн захирал: Б.Бямбадорж
Утас: 7772-1628 Цахим хаяг: byambadorj@growthfinance.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	21
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал.....	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	22
4.5.1 Завсрын аудитын талаар	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	24
5.1 Албан шаардлага.....	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НУББОХ	Нэгдсэн үндэстний байгууллагын байгаль орчны хөтөлбөр
ТБОНӨБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ШУА	Шинжлэх ухааны академи



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/387

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын онцлон тэмдэглэсэн хэсэг

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 7321 дүгээр тогтоолын дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой 304,425.9 мянган төгрөгийн хөрөнгийн үнийн шинэчлэн тогтоон данс бүртгэлд тусгаж тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хими, химийн технологийн хүрээлэн нь тайлант онд Шинжлэх ухааны академи, гадаадын хандив, тусламжаар хэрэгжиж байгаа 1,704,049.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 7 үндсэн хөтөлбөрийн хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 1,368,187.4 мянган төгрөг зарцуулан ажилласан байна. Энэ нь чиг үүргийн, үйл ажиллагааны давхардал, үр ашиггүй зарцуулалтыг үүсгэж болзошгүй.

Бусад асуудал

Хими, химийн технологийн хүрээлэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд ирүүлсэн бөгөөд Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн гаргаж, хамтран ажилласан.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Д.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Данс код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	533,123,386.60	444,185,463.32
33	АВЛАГА	376,063,582.54	346,540,369.75
33300	Татаас, санхүүжилтийн авлага	376,063,582.54	346,540,369.75
34	УРЬДЧИЛГАА	-	1,621,272.10
3471	Урьдчилгаа тооцоо	-	1,621,272.10
34714	Томилолтын урьдчилгаа	-	1,621,272.10
35	БАРАА МАТЕРИАЛ	157,059,804.06	96,023,821.47
351	Түүхий эд материал	10,941,798.67	24,160,013.47
35110	Тусгай зориулалттай материал	10,941,798.67	24,160,013.47
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,983,600.00	6,396,280.00
354	Хангамжийн материал	142,134,405.39	65,467,528.00
35410	Бичиг хэргийн материал	2,816,307.00	2,573,563.00
35420	Аж ахуйн материал	9,640,998.00	7,200,998.00
35430	Сэлбэг хэрэгсэл	68,796,708.00	22,478,885.00
35470	Бусад хангамжийн материал	60,880,392.39	33,214,082.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,306,067,135.09	8,434,569,809.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,306,067,135.09	8,434,569,809.19
392	Биет хөрөнгө	7,750,729,322.33	7,942,329,659.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,991,380,858.11	5,991,180,675.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	(981,570,714.12)	(1,144,855,619.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,111,296,649.47	4,401,105,124.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,541,924,606.12)	(1,507,719,874.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	380,675,185.00	431,547,955.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(217,790,006.17)	(237,590,557.91)
39217	Ном	8,661,956.16	8,661,956.16
393	Биет бус хөрөнгө	555,337,812.76	492,240,149.32
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,031,250.00)	(1,406,250.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	565,322,840.00	565,322,840.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(10,453,777.24)	(73,176,440.68)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,839,190,521.69	8,878,755,272.51
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,141,454.19	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,141,454.19	-
413	Өглөг	5,141,454.19	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,141,454.19	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,834,049,067.50	8,878,755,272.51
51	Засгийн газрын хувь оролцоо	8,834,049,067.50	8,878,755,272.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,282,597,658.51	3,282,597,658.51
51101	Өмч: - төрийн	3,282,597,658.51	3,282,597,658.51
512	Хуримтлагдсан үр дүн	2,550,504,120.54	2,595,610,690.55
51210	Өмнөх үеийн үр дүн	2,169,839,528.26	2,469,473,032.93
51220	Тайлант үеийн үр дүн	380,664,592.28	126,137,657.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,000,947,288.45	3,000,546,923.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,839,190,521.69	8,878,755,272.51

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,527,347,166.17	6,681,921,792.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	368,404,100.00	309,313,877.95
120	Нийтлэг татварын бус орлого	368,404,100.00	309,313,877.95
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	368,269,100.00	304,635,877.95
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	8,242,400.00	304,635,877.95
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	196,700.00	-
120009	Бусад орлого	135,000.00	4,678,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,158,943,066.17	6,372,607,914.94
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,236,937,900.00	5,044,621,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,236,937,900.00	5,044,621,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	922,005,166.17	1,327,986,214.94
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	265,629,666.17	267,946,504.94
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	498,620,700.00	185,720,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	157,754,800.00	874,319,710.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,146,682,573.89	6,521,331,785.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,146,682,573.89	6,521,331,785.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,104,728,830.54	6,243,230,967.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,212,526,641.10	4,006,135,627.50
210101	Үндсэн цалин	2,210,415,108.81	2,418,123,956.68
210102	Нэмэгдэл	567,871,761.04	704,485,792.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	203,591,931.25	408,945,293.35
210104	Урамшуулал	230,647,840.00	291,770,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	182,810,184.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	425,108,491.40	498,300,657.91
210201	Тэтгэврийн даатгал	282,682,961.65	340,233,431.76
210202	Тэтгэмжийн даатгал	31,261,417.78	38,794,130.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	34,707,046.71	19,452,309.04
210204	Ажилгүйдлийн даатгал	13,518,447.85	18,498,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	62,938,617.41	81,322,686.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,368,748.30	109,890,414.04
210301	Гэрэл, цахилгаан	33,018,523.33	37,180,743.63
210302	Түлш, халаалт	55,147,151.45	49,650,201.69
210303	Цэвэр, бохир ус	21,203,073.52	23,059,468.72
2104	Хангамж, бараа материалын зардал	15,874,906.33	40,052,474.39
210401	Бичиг хэрэг	8,912,093.00	11,001,154.00
210402	Тээвэр, шатахуун	4,156,300.00	3,535,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,186,513.33	1,316,831.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,620,000.00	960,000.00
210408	Бараа материал акталсны зардал	-	23,238,989.39
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,885,000.00	22,565,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	19,885,000.00	21,615,000.00
210604	Урсгал засвар	11,000,000.00	950,000.00
2107	Томиллолт, зочны зардал	65,234,308.10	76,949,745.54

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210701	Гадаад албан томилолт	18,634,008.10	30,780,360.50
210702	Дотоод албан томилолт	38,896,000.00	42,345,762.04
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	7,704,300.00	3,823,623.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	301,224,877.74	325,026,858.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	295,265,077.74	323,311,798.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	648,000.00
210807	Газрын төлбөр	959,800.00	1,067,060.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	944,505,857.57	1,164,310,190.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150,925,719.78	321,591,187.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	45,414,480.00	81,314,552.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	748,165,657.79	761,404,451.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,953,743.35	278,100,817.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,118,711.00	109,861,390.37
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	101,066,390.37
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,118,711.00	8,595,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,835,032.35	168,239,427.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,765,032.35	168,239,426.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	380,664,592.28	160,590,007.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	34,452,350.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(34,452,350.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	380,664,592.28	126,137,657.62

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,416,871,068.75	6,753,349,497.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	135,000.00	4,678,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	135,000.00	4,678,000.00
120009	Бусад орлого	135,000.00	4,678,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,416,736,068.75	6,748,671,497.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,236,937,900.00	5,044,621,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,236,937,900.00	5,044,621,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,179,798,168.75	1,704,049,797.48
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	311,991,076.09	339,216,073.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	696,312,994.16	490,514,014.48
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	171,494,098.50	874,319,710.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,809,004,163.75	6,086,646,797.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,809,004,163.75	6,086,646,797.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,388,982,837.86	5,462,005,610.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,216,813,989.73	4,003,888,724.97
210101	Үндсэн цалин	1,971,969,228.95	2,079,189,291.11
210102	Нэмэгдэл	826,933,812.14	1,085,125,404.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	198,240,500.36	406,412,458.05
210104	Урамшуулал	219,670,448.28	276,498,377.05
210105	Гэрээт ажлын хөлс	-	156,663,193.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	421,385,369.40	503,759,564.63
210201	Тэтгэврийн даатгал	303,121,169.40	358,798,174.21
210202	Тэтгэмжийн даатгал	31,425,800.00	37,008,590.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,472,900.00	18,498,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	14,472,900.00	18,498,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	57,892,600.00	70,956,600.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,257,148.58	109,890,414.04
210301	Гэрэл, цахилгаан	33,018,523.33	37,180,743.63
210302	Түлш, халаалт	57,035,551.73	49,650,201.69
210303	Цэвэр, бохир ус	21,203,073.52	23,059,468.72
2104	Хангамж, бараа материалын зардал	21,831,013.33	39,846,434.00
210401	Бичиг хэрэг	7,935,260.00	9,479,170.00
210402	Тээвэр, шатахуун	632,800.00	1,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,186,513.33	1,316,831.00
210404	Ном, хэвлэл	1,045,830.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,620,000.00	960,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,410,610.00	26,490,433.00
2105	Нормативт зардал	71,377,700.98	169,106,685.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,377,700.98	169,106,685.00

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	66,100,320.00	96,742,146.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,936,250.00	53,904,548.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	36,164,070.00	41,887,598.00
210604	Урсгал засвар	11,000,000.00	950,000.00
2107	Томилолт, зочны зардал	73,735,403.10	81,925,348.64
210701	Гадаад албан томилолт	18,634,008.10	32,161,632.60
210702	Дотоод албан томилолт	40,429,500.00	43,571,262.04
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	14,671,895.00	6,192,454.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	317,071,237.74	343,980,256.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	311,111,437.74	342,265,196.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	648,000.00
210807	Газрын төлбөр	959,800.00	1,067,060.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,410,655.00	112,866,037.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,198,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	89,410,655.00	104,668,037.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	420,021,325.89	624,641,187.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,122,711.00	109,861,390.37
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	200,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	101,066,390.37
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,122,711.00	8,595,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	388,898,614.89	514,779,796.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,765,032.35	168,239,426.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	607,866,905.00	666,702,700.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	607,966,905.00	666,702,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	607,966,905.00	666,702,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	607,966,905.00	666,702,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	607,966,905.00	666,702,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(607,966,905.00)	(666,702,700.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(100,000.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	100,000.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,282,597,658.51	3,000,947,288.45	2,172,733,028.28	8,456,277,975.24
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(2,893,500.02)	(2,893,500.02)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,282,597,658.51	3,000,947,288.45	2,169,839,528.26	8,453,384,475.22
Тайлант үеийн үр дүн	-	-	380,664,592.28	380,664,592.28
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,282,597,658.51	3,000,947,288.45	2,550,504,120.54	8,834,049,067.50
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(81,031,087.61)	(81,031,087.61)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,282,597,658.51	3,000,947,288.45	2,469,473,032.93	8,753,017,979.89
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(400,365.00)		(400,365.00)
Тайлант үеийн үр дүн	-	-	126,137,657.62	126,137,657.62
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,282,597,658.51	3,000,546,923.45	2,595,610,690.55	8,878,755,272.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,171,869,900.00	4,876,382,273.36	295,487,626.64	94.3
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,171,869,900.00	4,876,382,273.36	295,487,626.64	94.3
Төсвөөс санхүүжих	5,171,869,900.00	4,876,382,273.36	295,487,626.64	94.3
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,171,869,900.00	4,876,382,273.36	295,487,626.64	94.3
УРСГАЛ ЗАРДАЛ	5,171,869,900.00	4,876,382,273.36	295,487,626.64	94.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,034,044,600.00	4,771,815,882.99	262,228,717.01	94.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,727,692,600.00	3,577,567,764.53	150,124,835.47	96.0
Үндсэн цалин	1,797,619,700.00	1,809,531,524.45	(11,911,824.45)	100.7
Нэмэгдэл	1,227,866,700.00	1,085,125,404.98	142,741,295.02	88.4
Унаа хоолны хөнгөлөлт	446,027,200.00	406,412,458.05	39,614,741.95	91.1
Урамшуулал	256,179,000.00	276,498,377.05	(20,319,377.05)	107.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	467,817,800.00	450,275,390.42	17,542,409.58	96.3
Тэтгэврийн даатгал	311,014,000.00	305,314,000.00	5,700,000.00	98.2
Тэтгэмжийн даатгал	39,208,600.00	37,008,590.26	2,200,009.74	94.4
ҮОМШӨ-ний даатгал	19,598,100.00	18,498,100.00	1,100,000.00	94.4
Ажилгүйдлийн даатгал	19,598,100.00	18,498,100.00	1,100,000.00	94.4
Эрүүл мэндийн даатгал	78,399,000.00	70,956,600.16	7,442,399.84	90.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	142,433,900.00	109,890,414.04	32,543,485.96	77.2
Гэрэл, цахилгаан	50,162,000.00	37,180,743.63	12,981,256.37	74.1
Түлш, халаалт	65,802,700.00	49,650,201.69	16,152,498.31	75.5
Цэвэр, бохир ус	26,469,200.00	23,059,468.72	3,409,731.28	87.1
Хангамж, бараа материалын зардал	14,687,600.00	12,713,784.00	1,973,816.00	86.6
Бичиг хэрэг	2,141,800.00	2,054,000.00	87,800.00	95.90
Тээвэр, шатахуун	200,000.00	200,000.00	-	100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,355,700.00	1,316,831.00	38,869.00	97.13
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,831,900.00	960,000.00	871,900.00	52.40
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,158,200.00	8,182,953.00	975,247.00	89.35
Нормативт зардал	43,500,000.00	34,895,910.00	8,604,090.00	80.2
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	43,500,000.00	34,895,910.00	8,604,090.00	80.22
Эд хогшил, урсгал засварын зардал	506,705,300.00	468,309,360.00	38,395,940.00	92.4
Багаж, техник, хэрэгсэл	477,425,900.00	439,034,000.00	38,391,900.00	91.96
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	29,279,400.00	29,275,360.00	4,040.00	99.99
Томилолт, зочны зардал	6,742,500.00	6,742,500.00	-	100.00
Дотоод албан томилолт	6,550,000.00	6,550,000.00	-	100.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	192,500.00	192,500.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	91,659,000.00	78,614,960.00	13,044,040.00	85.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	84,094,100.00	76,899,900.00	7,194,200.00	91.45

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	-	5,000,000.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	648,000.00	648,000.00	-	100.0
Газрын төлбөр	1,916,900.00	1,067,060.00	849,840.00	55.67
Бараа үйлчилгээний бусад зардал	32,805,900.00	32,805,800.00	100.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	15,000,000.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,805,900.00	17,805,800.00	100.00	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	137,825,300.00	104,566,390.37	33,258,909.63	75.9
Бусад урсгал шилжүүлэг	137,825,300.00	104,566,390.37	33,258,909.63	75.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	15,186,000.00	200,000.00	14,986,000.00	1.32
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	119,339,300.00	101,066,390.37	18,272,909.63	84.69
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,300,000.00	3,300,000.00	-	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	117	100	-	85.5
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	97	80	-	82.5
Үйлчлэх ажилтан	11	11	-	100.0
Гэрээт ажилтан	8	8	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		1,708,727,797.48
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО		4,678,000.00
Нийтлэг татварын бус орлого		4,678,000.00
Бусад нийтлэг татварын бус орлого		4,678,000.00
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,704,049,797.48
Нэмэлт санхүүжилтийн орлого		1,704,049,797.48
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		339,216,073.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		490,514,014.48
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		874,319,710.00
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)		1,708,727,797.48
УРСГАЛ ЗАРДАЛ		1,708,727,797.48
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,356,892,427.29
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		426,320,960.44
Үндсэн цалин		269,657,766.66
Гэрээт ажлын цалин		156,663,193.78
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		53,484,174.21
Тэтгэврийн даатгал		53,484,174.21
Хангамж, бараа материалын зардал		27,531,650.00
Бичиг хэрэг		7,824,170.00
Тээвэр, шатахуун		1,400,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		18,307,480.00
Нормативт зардал		135,210,775.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		135,210,775.00

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Эд хогшил, урсгал засварын зардал		262,652,591.00
Багаж, техник, хэрэгсэл		230,587,353.00
Тавилга		16,300,000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		14,815,238.00
Урсгал засвар		950,000.00
Томилолт, зочны зардал		75,182,848.64
Гадаад албан томилолт		32,161,632.60
Дотоод албан томилолт		37,021,262.04
Зочин төлөөлөгч хүлээн авах		5,999,954.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		288,697,291.00
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		288,697,291.00
Бараа үйлчилгээний бусад зардал		87,812,137.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх		87,812,137.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		351,835,370.19
Бусад урсгал шилжүүлэг		5,295,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		5,295,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		346,540,370.19
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		346,540,370.19
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хими, химийн технологийн хүрээлэн нь “Эх орны амьтан, ургамал, микробын гаралтай түүхий бүтэц байгууламж, шинж чанарыг тогтоох, энэ чиглэлийн үйлдвэрлэлийн технологи, дизайныг хөгжүүлэх, байгаль орчны бохирдлыг бууруулах, хаягдал болон дайвар бүтээгдэхүүнийг боловсруулах, шинэ материал гарган авах технологид суурилсан судалгаа, шинжилгээний үйлчилгээ үзүүлэх” чиг үүрэг бүхий Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тус хүрээлэн нь эрхэм зорилгоо “Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн химийн аж үйлдвэрийг хөгжүүлэх шинжлэх ухааны үндэслэлийг бий болгох, химийн шинжлэх ухааныг шинэ мэдлэг, мэдээллээр баяжуулахад оршино” гэж тодорхойлсон байна.

Хүрээлэн нь 2025 онд зорилгын хүрээнд “Алсын хараа 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аюултай хог хаягдалд шинжилгээ хийх үндэсний стандартыг бий болгох, хүнс, хөнгөн үйлдвэрийн дайвар түүхий эдээс уургийн гидролизын бүтээгдэхүүн үйлдвэрлэх техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахын зэрэгцээ Шинжлэх ухааны Академийн менежментийн чадавхыг бэхжүүлэх, судалгаа, хөгжүүлэлтийн ажлын чанар, өгөөжийг дээшлүүлэх зорилтыг ханган ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус хүрээлэн нь Монгол улсын үндсэн хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль;
- Сангийн сайдын 2025 оны "Төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" шинэчлэн батлах тухай А/3 дугаар тушаал;
- Хууль зүй дотоод хэргийн сайдын 2025 оны А/100 дугаар тушаал “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”.

Хүрээлэнгийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үнэллээ.

Хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд Шинжлэх ухааны академийн дотоод аудитын албанаас шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус хүрээлэн нь Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад 2024 оны 9 дүгээр сард шилжин ирсэн бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг салбарын үйл ажиллагаатай холбогдуулан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн шинэчлээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36,564.8 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	376,063.6	346,540.4	(29,523.2)
Урьдчилгаа	-	1,621.3	1,621.3
Бараа материал	157,059.8	96,023.8	(61,036.0)
Үндсэн хөрөнгө	8,306,067.1	8,434,569.8	128,502.7
Нийт хөрөнгө	8,839,190.5	8,878,755.3	39,564.8
Өр төлбөр	5,141.5	-	(5,141.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,834,049.1	8,878,755.3	44,706.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,839,190.5	8,878,755.3	39,564.8

Авлагын дансны үлдэгдэл 346,540.4 мянган төгрөг болж 29,523.2 мянган төгрөгөөр буурсан нь нэмэлт санхүүжилтийн данснаас 346,540.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж Татаас санхүүжилтийн авлагаар тайлагнасантай холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 96,023.8 мянган төгрөг болж, 61,036.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд нийт 326,396.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, хүрээлэнгийн захирлын 2025 оны А/12 тоот тушаалын дагуу 66 нэр төрлийн 23,239.0 мянган төгрөгийн бараа материалыг акталж, 2025 оны А/23 тушаалаар 34,452.3 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн ангилалд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,434,569.8 мянган төгрөг болж 128,502.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвийн хөрөнгөөр 666,702.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, ТӨБЗГ-ын 2025 оны 7321 дүгээр тогтоолын дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох 304,425.9 мянган төгрөгийн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосон, бараа материалын данснаас шилжүүлэн бүртгэсэн хөрөнгийн ашиглах жилийн элэгдлийг тооцож үнийг бууруулан бүртгэсэн 14,792.4 мянган төгрөг, бусдаас үнэ төлбөргүй хүлээн авсан 210.0 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, тайланд онд тооцсон 857,628.5 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурснаас шалтгаалсан байна.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн Программ хангамжийн дансанд 93.6 мянган төгрөгийн өртөгтэй Хас эрин орчил ХХК-ийн динамик санхүүгийн программ бүртгэлтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус хүрээлэнгийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,330,658.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс ба нэмэгдэл урамшууллын зардлыг 617,459.5 мянган төгрөг, бусад урсгал зардлыг 664,047.2 мянган төгрөгөөр бууруулж, 5,049,151.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь хүрээлэнгийн төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйтэй холбоотой байна.

Тайлант оны батлагдсан төсвийг урсгал засвар хийх, тавилга эд хогшил худалдан авахтай холбоотойгоор 122,718.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,171,869.9 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,171,869.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, 4,876,382.3 мянган төгрөгийг зарцуулж, 127,248.2 мянган төгрөгийн санхүүжилт олгогдоогүй бөгөөд, 168,239.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,876,382.3 мянган төгрөг буюу 94.3 хувьтай байгаа нь цалин, шимтгэлийн зардлаас 167,667.2 мянган төгрөг, тогтмол зардал 32,543.5 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 1,973.8 мянган төгрөг, норматив зардал 8,604.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 13,044.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 13,044.0 төгрөг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	71805 - Шинжлэх ухаан, технологи	5,171,869.9	4,876,382.3	(295,487.6)	94.3
1.1	80101 - Үндсэн үйл ажиллагааны зардал	4,949,950.5	4,694,916.0	(255,034.5)	94.8
1.2	80219 - Харуул, хамгаалалтын зардал	76,900.0	76,899.9	(0.1)	100.0
1.3	80802 - Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	137,825.3	104,566.4	(33,258.9)	75.9
1.4	81569 - Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилээр гүйцэтгүүлэх	7,194.1	-	(7,194.1)	0.0

1. ШУА-ийн тэргүүлэгчдийн 2025 оны 04 дүгээр тогтоолын 15 дугаар хавсралтаар бүтэц орон тоог 117 хүнээр баталж, гүйцэтгэлээр 100 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан байна. Мэргэжлийн ажилтны ихээхэн дутагдалтай байдгаас тус хүрээлэнд орон тооны цомхотгол хийгдээгүй.
2. Тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтөд 446,027.2 мянган төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 406,412.5 мянган төгрөгийг зарцуулсан. Хими химийн технологийн хүрээлэнгийн захирлын 2024 оны Б/45 тушаалаар хоолны хөнгөлөлтийг нэг өдрийн 17.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлт нэг өдрийн 0.5 мянган төгрөг байхаар тогтоосон байна.
3. Тайлант онд тухайн байгууллага нь гадаад томилолт, гадаад зочин хүлээн авах арга хэмжээ зэрэгт зардал төсөвлөөгүй ба гүйцэтгэлээр зарцуулалт хийгээгүй байна.
4. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөн, түүнтэй адилтгах арга хэмжээнд зардал төсөвлөөгүй бөгөөд гүйцэтгэл гараагүй.
5. Тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай ажил, үйлчилгээний гэрээ байгуулаагүй, төлбөр төлөөгүй.
6. Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотойгоор гарсан зардал, олгосон нөхөн олговор байхгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 490,514.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 874,319.7 мянган төгрөг, гадаадын төслийн хүрээнд бий болсон 339,216.1 мянган төгрөг, бусад нийтлэг татварын бус орлого 4,678.0 мянган төгрөг нийт 1,708,727.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээт ажиллагсдын цалинд 426,321.0 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 53,484.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 27,531.7 мянган төгрөг, норматив зардал 135,210.8 мянган төгрөг, гэрээт төслийн дагуу төсөлт шаардлагатай тоног төхөөрөмж, урсгал засварын зардалд 262,652.6 мянган төгрөг, томилолт, зочны зардалд 75,182.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 288,697.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 87,812.1 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшуулалд 5,295.0 мянган төгрөг, нийт 1,362,187.4 мянган төгрөгийг зарцуулж, 346,540.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авах авлагаар тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хими, химийн технологийн хүрээлэн нь 2025 онд ШУА, гадаадын хандив, тусламжаар хэрэгжиж байгаа 1,704,049.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй төслийн хүрээнд нийт 7 хөтөлбөр, 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Гадаад төсөл	2022-2025	НҮББОХ-н тусгай хөтөлбөрийн сан, ургамлын хандуудыг ашиглан цайрын оксидын нанопартиклыг ногоон синтезийн аргаар гарган авах, будан барбад ургамлын суурь дээр бүтээгдэхүүн хөгжүүлэх боломж	Төсөл хөтөлбөрийн судалгааны ажил үргэлжилж байгаа	339,216.1	274,069.0
2	Хамтарсан төсөл	2023-2026	Нүүрсийг сольволиз, сонгомол болон катализаторт пиролизийн аргаар гүн боловсруулж үзүүрхэг кокс, германи болон нэмүү өртөг шингэсэн химийн бүтээгдэхүүн гарган авах, олборлолтыг дагалдах каолинитыг өндөр технологиор боловсруулан	Төсөл хөтөлбөрийн судалгааны ажил үргэлжилж байгаа	248,880.0	214,347.5

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

			ашиглахын зэрэгцээ антиоксидант идэвх сайжруулсан хитозан суурьтай биополимер зөөгч, хадгалалтад тогтвортой полисахаридаар бүрсэн хлорфиллын микрокапсул, мөн биополимерт суурилсан мөнгөний нанокөмпозит зэрэг инновацлаг биоматериалуудыг гарган авч үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, эм зүй, хүнсний салбарт хэрэглэх боломжийг судалсан цогц судалгаа			
3	Захиалгат төсөл	2022-2025	Дорноговь аймгийн Улаанбадрах суманд орших ураны орд газрын байгаль орчны мониторингийн судалгаа, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрээс гарах хүхрийн хүчлийг ашиглан бордоо үйлдвэрлэх технологи боловсруулах, мөн арьс ширний үйлдвэрийн уурагт хаягдлыг биотехнологийн аргаар боловсруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлийн судалгаануудыг хэрэгжүүлэх цогц ажил болно.	Төсөл хөтөлбөрийн судалгааны ажил үргэлжилж байгаа	184,434.0	178,241.7
4	Зүгшрүүлэлтийн төсөл	2022-2025	Өмхий шимэлдгийн эфирын тос агуулсан батганы эсрэг үйлдэлтэй гоо сайхны бүтээгдэхүүнүүд гарган авах" төсөл О.Сарангэрэл	Төсөл хөтөлбөрийн судалгааны ажил дууссан.	47,200.0	47,200.0
5	Грант төсөл	2025-2026	"Нефтийн гидро боловсруулалтад ашиглах цеолит Y катализын синтез" төсөл Б.Хулан	Төсөл хөтөлбөрийн судалгааны ажил дууссан.	10,000.0	10,000.0
6	Инновацийн судалгаа	2025-2026	"Коллагены пептидийн бэлдмэлийн биологийн идэвхийг фармакологи, клиникийн туршилтаар баталгаажуулж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх нь" ШУА-ийн инновацийн бүтээгдэхүүний судалгааны төсөл М.Баяржаргал	Төсөл хөтөлбөрийн судалгааны ажил үргэлжилж байгаа	57,975.0	45,584.0
7	Бусад төсөл	2025-2026	Судалгаа, үндсэн чиглэл хэрэгжүүлэх	Төсөл хөтөлбөрийн судалгааны ажил үргэлжилж байгаа	816,344.7	598,745.2
Нийт дүн					1,704,049.8	1,368,187.4

Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн нийт 28 төсөл хөтөлбөрөөс 13 төсөл хөтөлбөр бүрэн хэрэгжиж, судалгаа шинжилгээ, технологийн тайлан бүрэн бэлтгэгдсэн байна. Хэрэгжилтийн хугацаа дуусаагүй захиалгат, хамтарсан, ШУА-ын судалгаа хөгжүүлэлтийн нийт 15 төсөл, хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант хугацаанд тус хүрээлэн нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 666,702.7 мянган төгрөгийн төсөв өртөгтэй бараа ажил үйлчилгээг худалдан авсан нь ТБОНӨБАҮХАТ хуулийн холбогдох заалтуудтай нийцсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн хүрээлэнгийн үйл ажиллагааг сайжруулах санхүүгийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэлт хөтлөлт, анхан шатны баримтын бүртгэл хөтлөлт, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Гроут финанс аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Нансалмаа, аудитор Б.Хонгорзул, Б.Билгүүтэй нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтын менежер Ч.Хүнбиш, гүйцэтгэх захирал Б.Бямбадорж, Санхүүгийн аудитын газрын аудитор С.Алтанхуяг, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 1/10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,146,682.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож 51,466.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж материаллаг өөрчлөлт гараагүй тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд байгууллага хэмнэлтийн горимыг мөрдөн ажиллаж, зардлын сахилга батыг сайжруулсны үр дүнд нийт 295,487.6 мянган төгрөгийн зардлын бууралтыг бий болгосон. Үүнээс 127,248.2 мянган төгрөгийн

санхүүжилт батлагдсан хэмжээгээр олгогдоогүй бөгөөд 168,239.4 мянган төгрөгийг бодитоор хэмнэж төрийн санд буцаан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хими, химийн технологийн хүрээлэн нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 169 мэдээллээс 169 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төсвийн шууд захирагчийн 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг завсрын аудитад хамруулж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт авч, эрсдэлийг тодорхойлж аудитын ерөнхий стратегийг боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн таслан зогсоох 1 албан шаардлага, 12,237.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж өгснийг нотлох баримтад үндэслэн хянаж үнэлэхэд 85.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	100.0
Зөвлөмж	3	12,237.6	3	468.4	70.0
Нийт дүн	4	12,237.6	1	468.4	85.0

Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээний дагуу харилцагч и-Нэхэмжлэх үүсгэсэн тул татварыг харилцагч өөрөө хариуцах үндэслэлээр НДШ болон ХХОАТ-ыг суутгалгүй шилжүүлсэн тухай тайлбар ирүүлсэн бөгөөд үүнтэй холбогдуулан албан шаардлага хүргүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

1. Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар бэлтгэсэн тайланг Finperform программ шивэхэд төвөгтэй батлагдсан журмын маягт болон программын маягт, үзүүлэлтүүд ихээхэн зөрүүтэй, тодорхой журам заавар байхгүй, холбогдох байгууллагаас арга, аргачлал, зааварчилгаа өгөх дэмжлэг үйлчилгээ үзүүлдэггүй. Журам болон программын уялдааг сайжруулах арга хэмжээг холбогдох талуудаас авч ажиллах.
2. Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцсон эсэх.
3. Үндсэн цалинг Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоол цалингийн шатлал, ангиллын дагуу тогтоосон эсэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,703.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд таслан зогсоох 4 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн 5,703.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 45,763.4 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Засгийн газрын 2024 оны 238 дугаар “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор ТҮШУ-1 албан тушаалын цалингийн хэмжээ 1,283.0 мянган төгрөг байхад 1,500.0 мянган төгрөгөөр, ТҮШУ-2 шатлал 1,484.0 мянган төгрөг байхад 1,700.0 мянган төгрөгөөр, ТҮШУ-3 шатлал 1,559.0 төгрөг байхад 1,800.0 мянган төгрөгөөр, ТҮШУ-4 шатлал 1,637.0 мянган төгрөг байхад 1,900.0 мянган төгрөгөөр тус тус тогтоож, шатлалын зарчмыг зөрчсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-т "санхүү төсвийн удирдлагын асуудлаар өөрийн эрх хэмжээний хүрээнд заавар, журам батлан гаргах", Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт "Шинжлэх ухааны байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн хэмжээг илүү тогтоосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т заасан хөнгөлөлтийг 34 ажилтанд 1,752.0 мянган төгрөгөөр илүү эдлүүлснээс татварыг мөн дүнгээр дутуу, 35 ажилтанд 938.0 мянган төгрөгөөр дутуу эдлүүлснээс татварыг мөн дүнгээр илүү тайлагнажээ.

Энэ нь Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалын хавсралт "Хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 4.4.1-д "Тухайн тайлант жилийн 12 сард бүрэн тухайн байгууллагад харьяалагдаж ажилласан ажилтанд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг мөн хуулийн 27.1-д заасны дагуу жилийн эцэст өссөн дүнгээр тооцож, зөрүүг залруулж тайлагнана" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын хөнгөлөлтийг буруу тооцсон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс 3,013.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаж тайлагнаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дугаар зүйлийн 19.1.2-т "Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлс", 32 дугаар зүйлийн 32.2-т "Ажил олгогч дараах үүрэг хүлээнэ: 32.2.1.хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээ байгуулсан өдрөөс эхлэн ажилтныг нийгмийн даатгалд албан журмаар даатгуулах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээт ажилтныг нийгмийн даатгалд албан журмаар даатгуулаагүй, гэрээт ажлын хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл суутгаж тайлагнаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4. Анхан шатны баримтын бүрдлийг холбогдох хууль, журамд нийцүүлэн бүрдүүлээгүй, гэрээ, гэрээ дүгнэсэн акт иж бүрэн биш байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", мөн зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.3-т "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, мөн зүйлийн 14.3.1-т "анхан шатны баримт бүрдүүлэх" 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримт бичгийг холбогдох хууль, журамд нийцүүлж бүрдүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Засгийн газрын 2024 оны 238 дугаар “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор ТҮШУ-1 албан тушаалын цалингийн хэмжээ 1,283.0 мянган төгрөг байхад байгууллага 1,500.0 мянган төгрөг, ТҮШУ-2 шатлал 1,484.0 мянган төгрөг байхад байгууллага 1,700.0 мянган төгрөг, ТҮШУ-3 шатлал 1,559.0 төгрөг байхад байгууллага 1,800.0 мянган төгрөг, ТҮШУ-4 шатлал 1,637.0 мянган төгрөг байхад байгууллага 1,900.0 мянган төгрөгөөр тус тус тогтоож, шатлалын зарчмыг зөрчсөн байна.	1	-			1	-		
2	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т заасан хөнгөлөлтийг 34 ажилтанд 1,752.0 мянган төгрөгөөр илүү эдлүүлснээс татварыг мөн дүнгээр дутуу, 35 ажилтанд 938.0 мянган төгрөгөөр дутуу эдлүүлснээс татварыг мөн дүнгээр илүү тайлагнажээ.	1	2,690.0			1	2,690.0		
3	Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс 3,013.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаж тайлагнаагүй байна.	1	3,013.4			1	3,013.4		
4	Анхан шатны баримтын бүрдлийг холбогдох хууль, журамд нийцүүлэн бүрдүүлээгүй, гэрээ, гэрээ дүгнэсэн акт иж бүрэн биш байна.	1	-			1	-		
	Дүн	4	5,703.4			4	5,703.4		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 430/АД150079

Улаанбаатар хот

САГ-2026/257/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хими химийн технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2024 оны 238 дугаар "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолоор ТҮШУ-1 албан тушаалын цалингийн хэмжээ 1,283,000.00 /Нэг сая хоёр зуун наян гурван мянган/ төгрөг байхад байгууллага 1,500,000.00 /Нэг сая таван зуун мянган/ төгрөг, ТҮШУ-2 шатлал 1,484,000.00 /Нэг сая дөрвөн зуун наян дөрвөн мянган/ төгрөг байхад байгууллага 1,700,000.00 /Нэг сая долоон зуун мянган/ төгрөг, ТҮШУ-3 шатлал 1,559,000.00 /Нэг сая таван зуун тавин есөн мянган/ төгрөг байхад байгууллага 1,800,000.00 /Нэг сая найман зуун мянган/ төгрөг, ТҮШУ-4 шатлал 1,637,000.00 /Нэг сая зургаан зуун гучин долоон мянган/ төгрөг байхад байгууллага 1,900,000.00 /Нэг сая есөн зуун мянган/ төгрөгөөр тус тус тогтоож, шатлалын зарчмыг зөрчсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-т "санхүү төсвийн удирдлагын асуудлаар өөрийн эрх хэмжээний хүрээнд заавар, журам батлан гаргах", Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт "Шинжлэх ухааны байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11.хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал."-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цалингийн хэмжээг илүү тогтоосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хими химийн технологийн хүрээлэнгийн захирал /Л.Жаргалсайхан/, нягтлан бодогч /Н.Болортуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГРОУТ ФИНАНС ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Б. БЯМБАДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z: Alban Shaardlaga 2026/0125 SAG-74.Docx

1526180911



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 431/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/257/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хими химийн технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т заасан хөнгөлөлтийг 34 ажилтанд 1,752,000.00 /Нэг сая долоон зуун тавин хоёр мянган/ төгрөгөөр илүү эдлүүлснээс татварыг мөн дүнгээр дутуу, 35 ажилтанд 938,000.00 /Есөн зуун гучин найман мянган/ төгрөгөөр дутуу эдлүүлснээс татварыг мөн дүнгээр илүү тайлагнажээ.

Энэ нь Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалын хавсралт "Хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 4.4.1-д "Тухайн тайлант жилийн 12 сард бүрэн тухайн байгууллагад харьяалагдаж ажилласан ажилтанд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг мөн хуулийн 27.1-д заасны дагуу жилийн эцэст өссөн дүнгээр тооцож, зөрүүг залруулж тайлагнана" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал."-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Татварын хөнгөлөлтийг буруу тооцсон зөрчлийг таслаан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хими химийн технологийн хүрээлэнгийн захирал /Л.Жаргалсайхан/, нягтлан бодогч /Н.Болортуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГРОУТ ФИНАНС ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

[Signature]
Д.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

[Signature]
Б.БЯМБАДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 432/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/257/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хими химийн технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс 3,013,360.00 /гурван сая арван гурван мянга гурван зуун жар/ төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаж тайлагнаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дугаар зүйлийн 19.1.2-т "Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлс", 32 дугаар зүйлийн 32.2-т "Ажил олгогч дараах үүрэг хүлээнэ: 32.2.1.хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээ байгуулсан өдрөөс эхлэн ажилтныг нийгмийн даатгалд албан журмаар даатгуулах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11.хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал."д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээт ажилтныг нийгмийн даатгалд албан журмаар даатгуулаагүй, гэрээт ажлын хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл суутгаж тайлагнаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хими химийн технологийн хүрээлэнгийн захирал /Л.Жаргалсайхан/, нягтлан бодогч /Н.Болортуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М. Наранчимэг* Д.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР *Э. Энхбаатар* Э.ЭНХБААТАР
ГРОУТ ФИНАНС ХХК-ИЙН *Б. Бямбадорж* Б. БЯМБАДОРЖ
ЗАХИРАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z: Alban Shaardlaga\2026\0125 SAG-74.Docx

1526180926



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 433/А0150079

Улаанбаатар хот

САГ - 2026/257/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын бүрдлийг холбогдох хууль, журамд нийцүүлэн бүрдүүлээгүй, гэрээ, гэрээ дүгнэсэн акт иж бүрэн биш байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.3-т "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1-т "анхан шатны баримт бүрдүүлэх" 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1.нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй,"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримт бичгийг холбогдох хууль, журамд нийцүүлж бүрдүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хими химийн технологийн хүрээлэнгийн захирал /Л.Жаргалсайхан/, нягтлан бодогч /Н.Болортуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГРОУТ ФИНАНС ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

Б.БЯМБАДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 11-р хороо, Бижа тийрүү-33, Засагтын газрын 4 дүгээр байр,
Утас: 511-2164230

z7-Atharskhavandlgac@2609133586744Docx

1526180923